

УЛС ТӨРИЙН УХАМСРЫН ТӨЛӨВШЛИЙН АСУУДАЛД

Г.Цэнд-Аюуш

Ахлах багш

(МУИС, Улс төр судлалын тэнхим)

Даяарчлал дангааршлаар агуулга нь тодорхойлогдож байгаа түүхэн хөгжлийн шинэ зуун-XXI зуунд монгол түмний үндэсний улс төрийн ухамсар бидэнд онцгой чухал үүрэгтэй гэдэгт монгол хүн бүхэн санал нэгтэй байх нь хэн бүхэнд ойлгомжтой. Учир юун гэвэл монгол түмний үндэс угсаа, эх нутаг, соёл уламжлал, үнэт зүйлс, шүтлэг бишрэл, төрөө дээдлэх ёсон гэх мэт бүгд үндэстний өөрийн ухамсар хэмээх ойлголтоор илэрхийлэгдэн ирж байсныг судлаачид хүлээн зөвшөөрдөг! Аливаа үндэстэн бүрэлдэн төлөвших үйл явц хэд хэдэн үндсэн шинжийг агуулах бөгөөд түүнд хамгийн гол хоёр хүчин зүйл гол байр эзэлдгийг олонхи орны судлаачид тогтоосон байдаг. Германы улс төр судлаач М.Вебер хэлэхдээ “үндэстэн бол эв санааны нийтлэгийн цогц, улс төрийн хувь заяагаар холбогдсон нийтлэг, тиймээс аливаа үндэстний эрх, эрх чөлөөний үзэл санаагаа бусдаас дээдлэх нь тэргүүн зэргийн ач холбогдолтой” гэжээ. Ард түмэн, улс орон үндэстнүүдийн хөгжил, түүхэн дэвшил бүх үеийн туршид салангад тусгай байгаагүй, байж ч болохгүй бөгөөд улс орон, ард түмнүүд өөр хоорондоо нийгмийн амьдралын янз бүрийн хүрээ, салбарт тухайн цаг үеийнхээ нөхцөл байдал, өвөрмөц онцлогоос шалтгаалсан харилцаа, харилцан нөлөөлөл үзүүлж байдаг. Газар зүйн хувьд ойролцоо байрлалтай төдийгүй эдийн засаг, соёл шинжлэх ухаан боловсрол, мэдээлэл технологийн өргөн хэлхээ холбоотой улс үндэстнүүдийн ухамсар сэтгэлгээнд нийтлэг зүйлс олноор гарч ирдгийг үгүйсгэх аргагүй. Тухайлбал: Ази, Европ, Америкийн гэх мэт. Ийнхүү “улс төрийн ухамсар” хэмээх холбоо үг аль ч хэл дээр сонсогдож, тэмдэглэгдэж байлаа ч өдгөө хэн бүхэнд аль хэдийнээ танил сонсогдох болжээ. Хэдий тиймч улс төрийн ухамсрын төлөвшлийн төлөв байдал ард түмнүүдийн тэр дундаа монгол түмний амьдралын хэв маягт биежин төлөвших явдалд төвөг бэрхшээл байсаар байна тэр чанараараа судалгаа шинжилгээг шаардаж байгаа нь зүйн хэрэг юм. Учир нь “амьдралын түүх бол мөн чанараараа хувьслаар халхлагдсан ухамсрын хөгжлийн түүх... амьдрал бол ухамсрын өсөлт, дээшлэлт юм”¹ хэмээн францын эрдэмтэн Пьер Тейяр дэ Шарден бичсэн байдаг.

Гэхдээ оросын эрдэмтэн Бердяевийн хэлснээр өөрчлөлт шинэчлэлийг өрнөдийн үлгэр жишээгээр хийж болохгүй. Учир нь хоёр тэс өөр амьдрал байлаа. Тэр нь одоо монголчуудын амьдрал дээр харагдаж байна. Нөгөө талаар хөшүүн байдал, хүнд суртлын авторитар дэглэмийг шүүмжилсэн уриа лоозонгоор тэмцэл хийж хуучин тогтолцооноос шинэ ардчилсан тогтолцоонд шилжих шилжилтийн эхлэлийн үндэс суурийг тавьж эхлээд даруй 18 жил өнгөрлөө. Гэвч шинээр бүрэлдэн төлөвшиж байгаа ардчилсан засаглал нь тун сулхан нийгмийн амьдралын бүх салбарт хэдийгээр зарим амжилт ололт байгаа ч бүхэлдээ хүндрэл бэрхшээл, дутагдал нь нийгэм, төр үндэстэн, тусгаар тогтнолд ноцтой аюул учруулж болзошгүй хэмжээнд аль хэдийнэ хүрчихээд тогтвортой хөгжих чадвараар дорой байгааг манай зарим судлаачид тодорхой судалгаа, баримт сэлтэд тулгуурлан шудрагаар шүүмжлэн бичиж байна². Германы эрдэмтэн К.Поппер диктатураас ардчилалд шилжих үйл явц ардчиллаас диктатурт шилжихээс хэдэн зуу мянга дахин төвөг бэрхшээлтэй байдаг гэж хэлсэн байдаг. Тэхээр манай өнөөгийн гол асуудал бол нийгмийн амьдралын бүх

¹ А.Æàíààè Òàéýðàèçì. ÓÁ., 2006.52-53-ð òàè

² Ä.Äàíðóýà. Ñòèüàààðàè ò°ð. æ°æ°ð. 2001-10-18, Ñ.Äàààààà. Ìííàíèóí íèèòàíèéí öýíðàèààñ ñçèðýè ðçç, Ä.Äàø-íàíí, Áíàðíè áýñàèèàè, 1993 ¹ 1.2

салбар, бүтцэд тогтож байсан чанарын хэвшмэл байдлаас бүр өөр шинэ нөхцөл байдлыг бүрэлдүүлнэ гэсэн үг. Энэ чанарын шинэ нөхцөл байдал нийгмийн амьдралын бүх салбар, бүтцэд өөрчлөлт хийх төдийхнөөр бус харин өөрийн зөв үндэс суурьтай хөрс дэвсгэр дээр хөгжиж дэвших нөхцлийг хангана гэсэн үг. Ерөнхий сайд асан Элбэгдорж хөгжил гэдэг нь оршин тогтнож дэвжин дэвших чадавхи хөгжлийн түлхүүр нь нийгмийн үнэт зүйлс, баялаг бүтээмж гээд тэдгээрийг бүтээгч дархлагч нь хүн гэж томъёолон хүний хүчин зүйлийн ролийн ач холбогдлыг лекцэндээ тэмдэглэсэн байдаг! Залгамж үеэ тодорхой зорилго чиглэлтэй бэлтгэж хүмүүжүүлдэггүй нэг я ард түмэн, улс үндэстэн, нийгмийн бүлэг байдаггүй билээ.

Ингэхлээр эхлээд хүнийг өөрийг нь бас түүний ухамсрыг өөрчлөхгүйгээр (трансформация) бүтцийн хичнээн ч шинэчлэлт хийлээ ч гэсэн хүсэн хүлээж буй чанарын шинэ байдал бүрэлдэж чадахгүй. Харин ч нийгмийн хөгжлийн гол үзүүлэлтүүд тооны төдийгүй чанарын хувьд зогсонги байдал уналтад орж болзошгүйг түүх гэрчилнэ. Иймд аль ч нийгмийн хөгжлийн учир утгыг эрж хайхдаа “бүтцийн болон хүмүүсийн”, асуудлыг орхигдуулж үл болно²⁸Тухайн үеийнхээ агуу сэтгэгч К.Маркс “Фейербахын сэдвүүд”, бүтээлдээ “хүмүүс тухайн цаг үеийнхээ нөхцөл байдал, хүмүүжлийн бүтээгдэхүүн тэр нь өөрчлөгдвөл тэд бас өөрсдөө өөрчлөгдөнө²⁹”, бичиж байсан. Хэрэгцээ сонирхлоор хөлөглөгдөж улам бүр тодорхой утга агуулга нь тодотгогдгон биежиж сонголтын чиглэл олж авна.Хэрэгцээ сонирхол хүсэл тэмүүлэл үүсгэнэ,түүнээс зорилго,итгэл үнэмшил гарч ирнэ.Энд дурьдахад хичнээн их эрч далайц байгааг олж харж болно. Энэ бол ирээдүйгээ итгэл сэтгэлээр харах ухаан,үндэсний,бидний ойлгож байгаагаар улс төрийн ухамсрын төлөвшлийн асуудал юм. Судлаачид эхэн үедээ нийгмийн бүлгүүдийн улс төрийн ухамсар нь улс төрийн үйл явцад тодорхой хэмжээтэйгээр нөлөөтэй болохыг ажиглаад энэ хүчин зүйлийг үндэсний зан чанар гэдэг ойлголтоор илэрхийлж байсан нь саяхан билээ.Тиймээс олонхи улс төрийн нам, хөдөлгөөнүүд өөрсдийн прагматик зорилго, зорилтоо хэрэгжүүлэх явцдаа зөвхөн иргэдийн төдийгүй, ирээдүйг цогцлон бүтээгч залуучуудын ухамсар, үйл байдалд нөлөөлөх төдий биш тэдний юуны түрүүн улс төрийн ухамсрыг зөв чиглэлээр үнэт зүйлсийн чиг баримжаатай болгон төлөвшүүлэхэд ихээхэн анхаардаг нь тодорхой билээ.³⁰ Ер нь бие хүний улс төрийн нийгэмшлийн явцад улс төрийн ухамсар, үйл байдлын тодорхой хэв маяг бүрэлдэн тогтдог.

Эдүгээ ирээдүй рүүгээ тэмүүлсэн хэн боловч өөрсдийнхөө олсон ололтыг ч, туулсан бэрхшээл зовлон, алдсан алдааг ч ухааран ойлгон, алдаагаа засаж, амжилт ололтоо арвижуулахын тулд өнгөрснөөс өнөө үеийг хүртэлх монголын улс төрийн амьдрал тэр дундаа улс төрийн засаглалын субъектив талыг илэрхийлэгч институциональ биш элемент болох улс төрийн ухамсрын бүрдэлт төлөвшлийн талаарх судалгаа шинжилгээний шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Ер нь “улс төрийн ухамсар,, хэмээх категори улс төрийн бодлогын олон төрөлт ертөнцтэй харилцах харилцааг төдийгүй энэ ертөнцийн зүй тогтол, улс төрийн чиг баримжаа хандлагын ойлголтын түвшинг тусгадгаараа онцлогтой. Улс төрийн ухамсар төр, нийгмийн хөгжилтэй зэрэгцэн үүсэн хөгжиж ирсэн түүхэн зүй тогтолт үзэгдэл мөн учир тэр утгаараа улс төрийн системийн хувьд нэг дэд систем буюу Польшийн улс төр судлаач Ё.Вятрийн үзсэнээр “засаглал ба иргэн хоёрын хоорондын харилцааг хамарсан үзэл санаа, үнэт зүйлс, үйл байдлын хэв маягуудын нийлбэр цогцос,,⁶ мөн.

³ Ё.Вятр. 1991:13

⁴ Ё.Вятр, О.Уяааеу. Ёи-, 42. н.93-94.

⁵ А.Ё.Ёаіеі. ЁНН.ò. 13. н.376.

⁶ “.Ауòò. Ёиòèіаèу ііèèòè-аіèèò іòіòаіèè.і., 1978 н.

Аливаа улс үндэстэн бүр өөрийн гэсэн соёл иргэншилтэй, тэр нь өгсөн цэцэглэж, уруудан доройтож, дахин цэцэглэн мандах зэргээр улиран дэвшин хөгжинө. Энэ бол улс үндэстнүүдийн хөгжлийн нийтлэг жам ёсны түүх билээ.

Улиран одсон ХХ зууны эхэн үед судлаачид нийгмийн хөгжлийн янз бүрийн үзэгдлүүдийн нийтлэг шинж, түгээмэл зайлшгүй зүй тогтлыг танин мэдэхэд гол анхаарлаа чиглүүлж байсан бол эдүгээ үед үндэстний хөгжлийн онцлог, бусдаас ялгагдах ялгаа, өвөрмөц, давтагдашгүй, санамсаргүй тал шинжийг танин мэдэхэд анхаарлаа хандуулж үйл ажиллагаагаа чиглүүлэх боллоо.⁷

Улс төрийн ухамсрын бүрэлдэлт төлөвшилтөөс монголын нийгмийн ирээдүй ихээхэн хэмжээгээр шалтгаалах нь хэн бүхэнд ойлгомжтой. Энд залуучуудын тэр тусмаа тооны хувьд төдийгүй нийгмийн идэвхтэй бүлэг болсон оюутан залуучууд зохих ёсны байр сууриа эзлэх нь тодорхой билээ.

Оюутан залуучуудын улс төрийн ухамсар, хүмүүжлийн асуудлын ач холбогдлыг дутуу үнэлэх нь ялангуяа зах зээлийн хууль, механизм үйлчилж буй өнөөгийн нөхцөлд нэн аюултай. Улс төрийн ухамсар нийгэмд болж буй үйл явдал, үзэгдлийг тусгаж илэрхийлэх төдий биш, бас аливаа улс төрийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийн чиглэлийг бүрдүүлдгээрээ онцлогтой. Тиймээс улс төрийн ухамсрын судлах зүйлд өнөөдөр нийгэм ба бие хүний амьдрал үйл ажиллагааны бараг бүх талыг хамарсан асуудлууд хөндөгдөж байдаг гэсэн олонхи судлаачдын⁸санал дүгнэлтийг сайшаан дэмжиж байна.

Улс төрийн ухамсрын онол, практикийн асуудлыг судлан шинжлэхэд өрнөдийн болон оросын нэртэй эрдэмтэн судлаачид Г.Алмонд, Верб, Д.Истон, Х.Ласвелл, Э.Дюркейм, К.Манкейм болон Гаджиев.Б.С, Дилигенский.Г.Г, Иванов.В.Н, Бурлацкий.Ф.М, Грушин.Б.А. нар томоохон хувь нэмэр оруулжээ. Мөн монголын эрдэмтэн судлаачид Б.Даш-Ёндон, Түмэндэлгэр, С.Норовсамбуу, Дашжамц, Д.Содномгомбо, В.Отгоннасан, Л.Цэенбазар, Ц.Ганболд, Н.Хавх нар өөрсдийн эрдэм судлалын бүтээл туурвилдаа уг асуудалд анхаарлаа хандуулж байр сууриа илэрхийлж байжээ. Ер нь улс төрийн ухамсрын асуудлаар судалгаа шинжилгээний ажил ХХ зууны дунд үеэс өрнөдийн болон ЗХУ-д (хуучнаар) нийгэм судлалын салбарт өргөн хийгдсэн ба уг асуудлаар нилээд олон диссертаци хамгаалагдаж олон арван бүтээлүүд туурвигдсан байна.³¹ ? Улс төрийн ухамсрын талаарх тодорхойлолтод анализ хийх явцад хүндрэл гарч буй хэд хэдэн үндэслэл байна гэж бодож байна.

1. Улс төрийн шинжлэх ухаан өөрөө манайд шинэ тутам эхлэн хөгжиж байгаа тул түүний үндсэн нэг судлагдахуун болсон улс төрийн ухамсрын үзэгдэл эмпирик болон онолын судалгаанд бараг өртөгдөөгүй байна гэж хэлж болмоор байна.
2. Улс төрийн ухамсар хэмээх нэр томъёог тусгайлан хэрэглэсэн бүтээлүүд ХХ зууны дунд үеэс өрнөдийн орнууд болон ЗХУ-д (хуучнаар) дэлгэрч судалгаа шинжилгээний ажлууд хийгдэж хэд хэдэн докторын диссертациуд бичигдсэн хэдий ч улс төрийн ухамсрын талаарх өгөгдсөн 80 орчим тодорхойлолтыг авч үзвэл өгөгдсөн ба эрдэмтэн судлаачид өөр өөрсдийн үзэл баримтлалын байр суурь, хандлагаар тодорхойлсон байх юм.

⁷ Ἄ.Ἰῥίῶ-Ἰῥᾶύίύ. ἱάύῥῶίῶῆ ἱίῥῶί ἁῥῶῶῶῶ. Ὀῆ ῆ ῆῆῆ ῆῆῆῆ. Ὀῆ ῆ ῆ 31.1-16,101-109-ῆ ῆῆ

⁸ Ἰῆῆῆῆῆῆ ῆῆῆῆῆῆῆῆῆ ῆῆῆῆῆῆῆ ῆῆῆῆῆῆῆ ῆῆῆῆῆῆῆ ῆῆῆῆῆῆῆ ῆῆῆῆῆῆῆῆῆ

⁹ Современное политическое сознание в США.М.,1981,Политизация массового сознания в США 1981,ДилигенскийГ.Г Хэрэглээний нийгэм ба пролетари ангийн ухамсар МЭ и МО 1965№7,Массовое политическое è сознание в современном капитализме Вопросы психологий1971№9,Марксизм и проблемы массового политического сознания Вопросы философий 1983№11,Массовое политическое сознание рабочего класса капиталических стран:вопросы типологий.Рабочий класс и современный мир.1984№1,2

3. Улс төрийн ухамсрын асуудалд анализ хийж үзэхэд анхны судлаачид нь өрнөдийн социологи, политологийн эрдэмтэд байсан ба тухайн үеийн хоёр системийн хооронд өрнөж байсан үзэл суртал, ангийн тэмцлийн онцлогтой холбоотойгоор уг асуудалд ихэвчлэн анги, намын байр сууринаас хандан авч үзэж байсанд хэргийн учир оршино.
4. Улс төрийн шинжлэх ухааны категори нэр томъёоны асуудал дээр хүндрэл гарч байна хэвшээгүй учраас зарим ижил төрлийн утгатай категориудыг яаж нягтлаж авч үзэх тал дээр ихээхэн анхаарал тавих шаардлага гарсан бөгөөд оновчгүй хэрэглэсэн нэр томъёо, ойлголт байгааг үгүйсгэхгүй болно.

Улс төр судлалын нэн чухал асуудлуудын тоонд юуны өмнө засгийн эрхийн тухай асуудал,үүнтэй холбодон үүсэх улс төрийн харилцаа,энэ харилцааны илэрхийлэл болох улс төрийн институтүүдийн үйл ажиллагааны холбоо хамаарал,дээрхи харилцааны тусгал болох улс төрийн ухамсрын тухай асуудал багтан орох нь ойлгомжтой ¹⁰. Улс төрийн бодит байдалыг оюун санааны бүтэц болох үзэл суртал концепци онол, номлол мэдрэмж,сэтгэл санааны байдал зэрэггүйгээр үйлдлийн лоозон, хөтөлбөр болж хувирсан зэргийн явцыг тодорхойлж байгаа мэт санагддаг. Гэхдээ тийм үзэл суртал олон байдаг улс төрийн өөр бусад үзэл сурталчид, үнэт зүйлс дээдлэл чухал яагаад өндөрт өргөмжлөгдөж байдгийг тайлбарлах сонирхол зүй ёсоор гарч ирдэг. Үүнээс гадна бид нар хүн тус бүрээр улс төрийн сонголтыг бодитой хийхийг шаарддаг нөхцөл байдалд үе үе орохдоо сонгууль өнөөгийн улс төрийн лоозон, мөрийн хөтөлбөрийн эмх замбараагүй мэт янз бүрийн байдлыг бололцооныхоо хэрээр учрыг олж мэдэхийг эрмэлздэг билээ. Тийм сонголтын нөхцлийг бүрдүүлэх буюу улс төрийн ухамсрын хүрээ хэрхэн үйлчилдэг, тэр нь ямар байдлаар оршин тогтнодог, бүрэлдэж хөгждөг, ямар механизмтай байдгийг мэдэх нь гол билээ.

Ард түмэн, нийт Монгол түмний үндэсний эрх ашиг, тулгарч байгаа зорилтууд тэдгээрийг шийдвэрлэх ерөнхий хандлагатай нийцүүлэн зорилтоо тодорхойлж, зорилгоо хангаж чадахуйц зөв арга механизмыг сонгож чадсанаар хүний нийгэм улс төрийн идэвхитэй байр суурь илэрч хэрэгжих болно.

¹⁰ Á.Íðáííáñáí.Óëñ ò°ðèéí ñìòèíèíàè.Ñìòèíèíàè.2005 15.55-ð òàè